

Хууль, Эрх зүй



Мэргэжлийн үйлчилгээ



Үүрэг хүлээсэн хэрэглэгч



Мэдээлэл, Сурталчилгаа



2017

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ГАЗАР
ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ГАЗАР

Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн чиг үүрэг:

Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Эрчим хүчний хэмнэлтийн газрын тэргүүлэх чиглэл:

- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай эрх зүйн баримт бичгийг сайжруулах санал боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг тодорхойлох, бүртгэх, эрчим хүч хэмнэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан гүйцэтгэлийг гаргуулж авах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.
- Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, төгсөгчдөд эрх, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах.
- Эрчим хүчний аудит болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг магадлан итгэмжлэх эсэх саналыг хорооны хурлаар хэлэлцүүлэх, зохих шийдвэрийг гаргуулах.
- Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаар мэдээллийн систем бий болгох, нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах.
- Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулахад чиглэсэн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах талаар санаачлагатай ажиллах.
- Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс бий болж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахаар дэлхийн улс орнуудын нэгэн адил Эрчим хүчний үр ашигтай хэрэглээнд суурилсан хэмнэлтийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бодлого, Хууль Эрх Зүйн Чиглэлээр:

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /2018-2022/

-Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль,
-Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030 /2016/,
-Ногоон хөгжлийн бодлого /2014/,
-Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015/,
-Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /2015/,
-Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр /2011/,
-Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр-2030 /2015/,
-Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр /2017/
-Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлого, хууль тогтоомжид инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр заасныг үндэслэл болгож **Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр /2018-2022/**-ийн төслийг боловсруулав. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлагдсан.

ДҮРЭМ, ЖУРМЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9.г-д заасны дагуу “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулав.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдах энэ журмаар дэвшилтэд техник, технологийг дэмжих, хэрэглээнд нэвтрүүлэх, эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараа болон барилга, барилгын материалын эрчим хүчний хэрэглээнд ангилал, зэрэглэл тогтоох, тэдгээрийг шошгожуулах үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар нарийвчлан зохицуулахаар тусгав.

ЗААВАР, АРГАЧЛАЛ, ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД


“Эрчим хүчний аудит хийх гарын авлага”-ыг боловсруулж 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Хорооны хурлаар хэлэлцүүлж 49 дүгээр тогтоолоор батлуулсан.

Аудитын гарын авлагын төсөлд ГОУХАН-ийн ЭХСҮАТ-ийн зөвлөх Алберт Каупп, Энэтхэгийн эрчим хүч хэмнэлтийн хорооны зөвлөх К.К. Чакарварти нараас санал шүүмж авч сайжруулалт хийсэн. Мөн Эрчим хүчний аудиторуд болон салбарын зөвлөх инженерүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, зөвлөмжийг тусгаж, засвар сайжруулалтыг хийсэн.

Эрчим хүчний аудитын жишиг үнийг тогтоохын тулд ОХУ, Украины эрчим хүчний аудиторын цалин хөлсийг судалсан. Энэхүү судалгаа нь Монголд эрчим хүчний аудиторын цалин хөлсийг тооцох аргачлалд суурь судалгаа болж өгсөн.


“Эрчим хүчний аудит хийх гэрээний загвар”-ыг боловсруулж Хорооны хурлаар хэлэлцүүлж 2017 оны 96 дугаар тогтоолоор батлуулсан.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, журам, эрх зүйн баримт бичиг боловсруулалт:



Эрчим хүчний сайдын 2017 оны 52 дугаар тушаалаар *Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг* боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдав. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3 дахь заалтыг удирдлага болгон Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, ажлын хэсгийн хэмжээнд 3 удаагийн хурал зохион байгуулж, сайжруулалтыг хийсэн. Мөн олон нийтийн хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулж салбарын эрдэмтэн судлаачид, зөвлөх инженерүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулсан нийт 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан санал авч 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Эрчим хүчний сайдын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийг Эрчим хүчний сайдын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 39 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна.

Монгол улсад импортоор оруулж ирдэг эрчим хүчээр ажилладаг машин тоног төхөөрөмжийн судалгааг 2016 оны байдлаар ангилан судалж, Эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмын төслийг боловсруулахад үндэслэл болгон ашиглав.



Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээний чиглэлээр:



Эрчим хүчний аудитор, менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу эрчим хүчний аудитор бэлтгэх 15-18 модультай, 45 хоногийн сургалт, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх 18 модультай, 28 хоногийн сургалтыг зохион байгуулав.

2017 онд ШУТИС-ын Эрчим хүчний Сургууль, Эрчим хүчний хөгжлийн төв, ШУТИС-ын Барилгын архитектурын сургуультай хамтран эрчим хүчний аудитор бэлтгэх 2 удаагийн 44 суралцагчтай, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх 4 удаагийн 88 суралцагчтай сургалтыг амжилттай зохион байгуулсан. Одоогоор үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 74% нь өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах орон тооны ажилтныг томилон, эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалтад хамруулаад байна.

Эрчим хүчний зохицуулах хороон даргын 2017 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн А/05 тушаалаар томилогдсон 10 гишүүнтэй шалгалтын комисс нь холбогдох журмын дагуу эрчим хүчний аудитор, менежерийн эрх олгох 6 удаагийн шалгалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж тайлант жил 27 үйлдвэрлэлийн, 17 барилгын эрчим хүчний аудитор, 86 эрчим хүч хэмнэлтийн менежер тус тус гэрчилгээ олгосон байна.

Мэргэжилтнүүдийг чадавхжуулах, чиглэл, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор:

- Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн эрчим хүчний аудитын жишиг төслийн хүрээнд аудиторын мэдлэг дээшлүүлэх сургалт 2 удаа зохиож 41 хүн оролцсон;
- Аудитын үйлчилгээний хөлс сэдвээр хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж 70 орчим хүмүүс оролцов;
- Мэдлэгийн цаг лекцийг “Эрчим хүч хэмнэлтийн дэвшилтэт техник, технологи”, “Эрчим хүчийг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх боломж ба шийдэл” сэдвээр 2 удаа зохион байгуулж 57 эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежерүүдэд мэдлэг олгов.

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалт



Үүрэг хүлээсэн хэрэглэгчидтэй хамтран ажиллах, дэмжих чиглэлээр:

Засгийн газраас тогтоосон эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг давсан хэрэглээтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын 2016 оны эрчим хүчний хэрэглээний мэдээллийг шинэчлэн авч “Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг нэмж бүртгэх, зарим хэрэглэгчийг бүртгэлээс хасах тухай” асуудлыг хорооны хурлаар үе шаттай хэлэлцүүлж 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 127 дугаар тогтоолоор үүрэг хүлээсэн хэрэглэгчийг шинээр тодорхойлж бүртгэсэн. 2017 оны байдлаар нийт давхардсан тоогоор 133 үүрэг хүлээсэн хэрэглэгч байна.

Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэхэд дэмжих

Үүрэг хүлээсэн 133 аж ахуйн нэгж байгууллагад Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах тухай “Зөвлөмж”-ийг боловсруулж хүргүүлсэн. Одоогоор үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 80 орчим хувь нь өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах орон тооны МЕНЕЖЕР-ийг томилон ажиллаж байна.

Хуулийг таниулах, ач холбогдлыг ойлгуулах чиглэлээр

Хууль сахиулахын их сургууль, Шастины нэрэмжит 3-р эмнэлэг, МУБИС, МУИС, ХААИС, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Блюскай эйжиа” ХХК, Шангрила Улаанбаатар зочид буудал, Хилийн цэргийн 0288-р анги, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар, Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар, МҮОНРТ, Дулаан шарын гол” ТӨХК, “АПУ” ХК, “Мишээл групп” ХХК, “Улаанбаатар их дэлгүүр” ХХК, “Нарантуул трейд” ХХК, “Чингис хаан цогцолбор” ХХК, “Номин холдинг” ХХК, ОНААУГ, “Шарын голын уурхай” ХХК, Худалдаа хөгжлийн банк зэрэг Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн удирдлага, менежерүүдтэй газар дээр нь уулзалт зохион байгуулж эрчим хүчний аудит, хэмнэлтийн хөтөлбөр төлөвлөгөө болон цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөгөөн өгч ажилласан.

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг дэмжих чиглэлээр

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага (GGGI)-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр эрчим хүчний аудитын жишиг төслийг үүрэг хүлээсэн 15 аж ахуйн нэгж, байгууллага дээр амжилттай хэрэгжүүлж ажилласан. Энэ ажлын гүйцэтгэгчээр олон улсын зөвлөх үйлчилгээний “Прайс Уотерхаус күүперс” компани шалгарч 5 сарын хугацаанд хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү аудитын зөвлөмжийн дагуу эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 58 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах, жилдээ 259.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч буюу 35.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж, хөрөнгө оруулалтын зардлаа дунджаар 3 жилийн дотор нөхөж, нийтдээ 620 гаруй мянган тонн CO₂ /хүлэмжийн хий/ ялгарлыг бууруулах боломжтой гэсэн дүгнэлт гарсан.

Эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг сурталчилгах ажлын хүрээнд:

Эрчим хүчний хэмнэлтийн холбогдох хууль журмуудын талаар мэргэжлийн байгууллагуудад хандсан дараах ажлыг зохион байгуулсан.

“Энержи Монголиа-2017” хурал, Салбарын 95 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Инженерүүдийн зөвлөгөөн”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форум”, БНХАУ-д зохион байгуулагдсан “Ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ” олон улсын хурал, Үүрэг хүлээсэн хэрэглэгчидтэй хийх уулзалт, “Бүсийн зөвлөгөөн” зэрэг хурал, арга хэмжээнүүдэд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлийн танилцуулга, илтгэлийг тавьж оролцсон.

Төв, Баруун, Зүүн бүсийн уулзалт зөвлөлтөнд эрчим хүчний хэмнэлтийн бий болгох, хуулийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөмж, илтгэлийг бэлтгэн танилцуулсан. Мөн уг зөвлөгөөний мэдээллийг агуулсан Эрчим хүч & инженеринг сэтгүүлийн тусгай дугаарыг бэлтгэн, 1000 хувь хэвлүүлж эрчим хүчний салбарын байгууллагуудад тараасан.


Салбарын ИТА, бүх шатны окутан сурагчдад зориулсан эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр “Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ, хэмнэлтийн асуулт хариулт” номыг зохиож нийтийн хүртээл болгосон. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 20 орчим компаниудад 300 хувь хүргүүлж, олсон орлогоос 4.0 сая төгрөгийг Хорооны шинэ жил зохион байгуулахад зарцуулсан.

Аймаг, нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүдэд “Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх арга зам” илтгэл тавьж, зөвлөмж боловсруулан өгсөн.

2017 оны 12 дугаар сарыг “ДУЛААН ОРЧИН-ХЭРЭГЛЭГЧИЙН АЯ ТУХ” сэдэвт хэрэглэгчийн сарын аян болгон зарласантай холбогдуулан “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-тай хамтарсан Дулаан түгээх, дулаанаар хангах үйл ажиллагаа эрхлэгчдэд мэдээлэл, зөвлөмж өгч ажиллав.



Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг холбоотой олон нийтэд хандсан сурталчлан таниулах зорилготой дараах ажлуудыг хийлээ:



Чингисийн талбайд 2017 оны 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан эрчим хүчний салбарын нээлттэй хаалганы өдөрт оролцож Эрчим хүч хэмнэлтийн хууль эрх зүй, хэмнэлтийн асуудлаар хэрэглэгчдийн сонирхсон асуултад хариулж, холбогдох гарын авлага, материалаар хангаж, эрчим хүчний хэмнэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч ажиллалаа.

МҮХАҮТ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд В2В уулзалтыг зохион байгуулсан.

Иргэдийн эрчим хүчний боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Захираа хүний нөөцийн хэлтэстэй хамтран 9 телевизэд 14 ярилцлага өгч, 18 сайтад Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөр, жишиг аудитын талаар мэдээлэл гарган, 3 сонинд 3 удаа, 2 сэтгүүлд 4 удаа мэдээлэл хэвлүүлж, гарын авлага, ном 4, инфографик 17, самбар 6, зураг хуудас 1, брошур 2 тус тус хэвлүүлсэн байна. Хорооны цахим хуудасны мэдээ буланд 30 удаа мэдээлэл бэлтгэж оруулсан.

ЭХЗХ-ны цахим хуудсаар дамжуулан мэдээ мэдээлэл оруулж баяжуулан ажиллаж байна. Мөн “Эрчим хүчний үнэ цэнэ” фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны вэб сайтны “эрчим хүчний хэмнэлт” цэсийг шинэчлэн холбогдох мэдээллүүдийг байршуулав

Дараах таван чиглэлээр 22 төрлийн мэдээллүүдийг нэгтгэсэн:

- Хууль эрх зүй,
- Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ,
- Эрчим хүч хэмнэлтийн сургалт,
- Үүрэг хүлээсэн хэрэглэгч,
- Эрчим хүч хэмнэлттэй холбоотой мэдээлэл зөвлөмж.

Энэхүү мэдээллийн цэсийг шинэчилснээр эрчим хүч хэмнэлт, үр ашгийн мэдээллийн систем үүсэх суурь болж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, “УБЦТС” ТӨХК-тай хамтран “Дэд бүтцийн хяналтад - таны оролцоо” сэдэвт сарын аяныг 2017 оны 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулав. Сарын аяны хүрээнд цахилгаан эрчим хүчний зохистой хэрэглээ, хэмнэлтийн ач холбогдлыг сурталчлан таниулах, ЧД-ийн 72 дугаар сургуулийн цайны газрын хийн тоноглол, цахилгааны ерөнхий болон хуваарилах цэцгийг иж бүрэн шинэчилж, нийтдээ 15 сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн.

Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар олон нийтэд таниулах, сурталчлах ажлын хүрээнд Нийслэлийн Боловсролын газартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээл заах багш нарыг бэлтгэн, туршилтын журмаар 11 сургуульд хичээлийг заав. Бага ангийн сурагчдын амьдрах чадварт суралцах цагийн хичээлд “Эрчим хүч-зохистой хэрэглээ” сэдэвт хичээлийг тусгаж, нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулан батлуулав.

Хичээлийн хөтөлбөрт зориулж 11 үзүүлэх хичээлийг видео хэлбэрээр бичиж, багш нарт гарын авлага болгон бэлтгэсэн.

Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх арга зүйг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж, сургалтад амжилттай хамрагдсан 33 багшид сургагч багшийн “Батламж” олгох ажлыг зохион байгуулсан.

Эдгээр бэлтгэсэн багш нараар дамжуулан зорилтот бүлгийн бага ангийн 230 багшид хичээлийн агуулга, хөтөлбөрийг танилцуулах сургалтыг сургууль тус бүр дээр явуулсан.

Хамтын ажиллагааны эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын тайланг сургууль бүр ирүүлсэн бөгөөд уг дурдсанаар нийт 230 багш, 6000 сурагч, 300 эцэг, эхэд эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээл заагдсан байна.



Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны чиглэлээр:

Төсөл хөтөлбөрүүд, гадаад хамтын ажиллагаа:

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага (GGI)-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр эрчим хүчний аудитын жишиг төслийг үүрэг хүлээсэн 15 аж ахуйн нэгж, байгууллага дээр амжилттай хэрэгжүүлж ажилласан. 2018 онд хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан идэвхтэй хамтран ажиллаж байна.

Мөн Эрчим хүчний салбарын компаниудад бодит хэмнэлтийг бий болгох, бусад байгууллагуудад сайн туршлага, загвар болгох зорилгоор “ДЦС-3” ТӨХК, “УБЦТС” ТӨХК, “УБДС” ТӨХК, “Налайхын дулааны станц” ТӨХК-д хийсэн жишиг аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэмнэлтийн загвар төсөл хэрэгжүүлэх санаачилгыг гаргаж, тодорхой ажил зохион байгуулж ажиллав. Энэ дагуу “ДЦС-3” ТӨХК-нд “Монхорус интернейшнл” ХХК-тай хамтран эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн арга хэмжээг хэрэгжүүлэх жишиг (ЭСКО) төсөл хэрэгжүүлэх талаар бэлтгэл ажил ханган ажиллаж байна.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГЫГ НӨМӨГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - 3-р ДУГААНЫ ЦАХИГААР БАЛАНС СТАНЦ

2016 | 080-0000-976,974,300

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГЫГ НӨМӨГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - 3-р ДУГААНЫ ЦАХИГААР БАЛАНС СТАНЦ

2016 | 080-0000-976,974,300

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГЫГ НӨМӨГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - 3-р ДУГААНЫ ЦАХИГААР БАЛАНС СТАНЦ

2016 | 080-0000-976,974,300

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГЫГ НӨМӨГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - МОНГОЛЫН ҮНДСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТӨЛӨВ

2016 | 080-0000-976,974,300

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГЫГ НӨМӨГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - МОНГОЛЫН ҮНДСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТӨЛӨВ

2016 | 080-0000-976,974,300

Германы олон улсын хамтын нийгэмлэгийн “Эрчим хүчний үр ашиг 3+” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улсад ЭСКО буюу эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйлчилгээний бизнес эрхлэх зах зээлийн механизмыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн загварыг бий болгох ажлыг тусгуулан, ажлын даалгаврыг боловсруулж хүргүүлсэн.

Энэ ажлын хүрээнд эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, ЭСКО ба хэрэглэгчийн хооронд байгуулах хэмнэлтийн гэрээний загваруудыг боловсруулах ба ЭСКО бизнес төлөвлөгөө боловсруулах арга зүйн зөвлөмж гаргана.



БНСУ-ын Эрчим хүчний агентлаг (KEA)-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийг байгуулснаар хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухайлбал эрчим

хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр судалгаа хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд харилцан туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, дэмжлэг үзүүлэх юм. 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах тухай санал хүргүүлэн ажиллаж байна. БНСУ-ын Эрчим хүчний агентлаг (KEA)-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Энэхүү санамж бичгийг байгуулснаар хоёр тал харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухайлбал эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр судалгаа хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд харилцан туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, дэмжлэг үзүүлэх юм. 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах тухай санал хүргүүлэн ажиллаж байна.

Эрчим хүчний хэмнэлтийн даатгалыг нэвтрүүлэх зах зээлийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг хийж байгаа Шведийн судалгааны байгууллага (BASE) болон Хас банктай уулзалт зохион санал солилцон ажиллаж байна.



Нэгдсэн үндэсний аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO): Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ЭХЗХ-оос аж үйлдвэрийн салбарт эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулах зорилгоор "ISO 50001-Эрчим хүчний удирдлагын тогтолцоо" стандартыг нэвтрүүлэх төсөл санаачлан ажиллаж байна. Уг төслийг Даян дэлхийн байгаль орчны сан (GEF)-гийн санхүүжүүлэх бөгөөд техникийн тусалцаа хэлбэрээр хэрэгжинэ. Төслийн нийт өртөг 2 сая. ам.доллар. Энэ хүрээнд хийсэн ажлуудаас дурдвал: Монголын Үйлдвэрийн салбарт эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэх, мөн олон улсын стандарт нутагшуулах талаар UNIDO-той хамтарч хэрэгжүүлэх төслийн саналын анхны хувилбарыг боловсруулсан.

- Даян дэлхийн байгаль орчны сангийн Монгол Улс дахь төлөөлөгч болон Хорооны даргад төслийн талаар танилцуулгыг хийсний үндсэн дээр ЭХЯ-нд албан тоот хүргүүлсэн.
- ЭХЯ-тай хамтран UNIDO болон Байгаль орчин аялал жуулчлалын яаманд тус төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай албан хүсэлтүүдийг тус тус явуулсан.
- НҮБ-ийн Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагатай Даян дэлхийн байгаль орчны санд төслийн баримт бичгийг албан ёсоор хүргүүлж төслийг санхүүжүүлж өгөх хүсэлтийг илэрхийлсэн.

БНХАУ-ын Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын төлөөлөлтэй хамтран ажиллах талаар уулзалтыг зохион байгуулсан.

Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-тай хамтран хэрэгжүүлж буй Ногоон барилгын үнэлгээний системийн уулзалт, семинарт оролцож EDGE тооцооны хэрэгслийг ашиглан туршив.

Төрийн болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа:

“Эрчим сүлжээ” ХХК, “БСД Эрчим хэмнэлт” ХХК, “Стэйт консалтинг” ХХК зэрэг эрчим хүчний аудитын компаниудтай хамтран ажиллаж “Эрчим сүлжээ” ХХК-ийн “ДЦС- 2” ТӨХК дээр хийсэн аудитын тайланг хүлээн авч тус компанийн аудиторруудтай уулзалт хийж аудитын тайланд холбогдох нэмэлт өөрчлөлтийг хийж байна.

Монголын Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнтэй хамтран “Эрчим хүчний хэмнэлтийн үзүүлэлтүүдийг /индикатор/ тодорхойлох” судалгааны баримт бичиг боловсруулах ажлыг хийлээ. Энэхүү судалгааны ажлыг Олон улсын эрчим хүчний судалгааны хүрээлэнгүүдийн холбоо (ERIN)-ны тусламжтайгаар хийхээр эхний санал өгсөнд холбооны зүгээс дэмжсэний дагуу баримт бичиг боловсруулах саналыг дахин эцэслэн боловсруулж д хүргүүлсэн. Тус судалгааны ажил нь 65000 ам. долларын санхүүжилтээр 2 жилийн хугацаанд хийгдэж олон улсын тэргүүн туршлага дээр үндэслэн эрчим хүчний индикаторуудыг тодорхойлох талаар бодлогын зөвлөмж агуулсан тайлан боловсруулна.

“Барилга хот байгуулалтын яам” -аас зохион байгуулсан Олон улсын санхүүгийн корпорацийн “Монгол Улсад Ногоон барилгыг хөгжүүлэх нь” болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжихээр төлөвлөсөн “Монгол Улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” /НАМА/ төслийн нээлтэд оролцож ЭХХ-ийн тухай хууль болон түүнд холбогдох журмуудын талаар санал өгч ажилласан. Мөн Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан НОГООН БАРИЛГЫН ЗӨВЛӨЛ-ийн бүрэлдэхүүнд ажиллаж, зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангах, ажлын уялдааг хангах, үйл ажиллагааны давхардлыг арилган ажиллаж байна.

2017 оны 12 сарын 19-ны өдөр ДДНХБ, ЭХЗХ болон Нийслэлээс хамтран зохион байгуулж буй “Уур амьсгалын хөрөнгө оруулалтын түншлэл” форумд танилцуулах илтгэл тавьж оролцсон.



Implemented by:



Global
Green Growth
Institute



Empowered lives.
Resilient nations.



KOREA ENERGY
AGENCY



KESCO



Монголын Банкны холбоо, БОАЖЯам хамтран 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн форум 2017” чуулга уулзалтад оролцож, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай хамтран 15 аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжүүлсэн эрчим хүчний аудитын жишиг төслүүдийг чуулганд оролцогч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллагын төлөөллүүдэд танилцуулсан. Ногоон зээлийн бодлогыг дэмжих зорилгоор Хас банкаас зохион байгуулсан “Ногоон санхүүжилтийн анхдагчаар чуулган” зэрэг банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах алхмуудыг бүрдүүлж, хамтран ажиллаж байна.



Эрчим хүчний газраас санаачилж хийсэн ажил:

- 2018 оныг эрчим хүчний салбарын хэмжээнд “Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн жил” болгон зарлах санаачлага дэвшүүлсэн нь удирдлагаас дэмжигдсэн.
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг олон улсын хуулийн фирмээр орчуулуулах ажлыг зохион байгуулсан.
- Хорооны шинэ барилгыг эрчим хүчний хэмнэлттэй төслөөр хийх талаар зургийн компанитай хамтран ажиллаж, барилгын дулаан алдагдалгүй, цахилгааны ба дулааны эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчийг ашиглан хэрэглээгээ хангах, автоматжуулалт бүхий ухаалаг байх шийдлүүдийг ажлын зураг төсөлд тусган ажиллаж байна.
- Хорооны өргөтгөлийн барилгын халаалтын эрчим хүчний хэрэглээг тооцох, үр ашигтай, хэмнэлттэй болгох зорилгоор, мөн айл өрхийн дулааны төлбөр тооцоог хэрэглээнд суурилсан төлбөрийн аргад шилжүүлэх суурь судалгаа хийх зорилгоор “Икон” ХХК-тай хамтран төсөл хэрэгжүүлэв.
- Төслийн хүрээнд нийт 33 халаах хэрэгсэлд “Икон” ХХК-ийн санхүүжилтээр дулаан хэмжигч-аллокатор, Хорооны санхүүжилтээр термостат тохируулагч хаалт суурилуулж заалтуудыг тогтмол авч үр ашгийн тооцоолол хийж байна.
- Дулаан хэмжигч-аллокатор тавьсны дараах эхний 2 сарын хэрэглээнд шинжилгээ хийхэд зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 сард 57.757 төг, 11 сард 189.323 төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ халаалтын улиралд 1.300 мянган төгрөг хэмнэх тооцоолол гарч байна.



БУСАД АЖИЛ:

БОАЖ-ын сайдын 2017 оны а/148 тушаалаар агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгтэй хамтарч ажиллан Эрчим хүчний салбарын үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, хөтөлбөрт тусгуулсан.

Ашиглагдаж буй барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээг тооцон гаргах, шошгожуулалтын журамд барилга байгууламжийг хамруулах судалгааг Завхан аймгийн Улиастай сумын 7 болон 5 дугаар цэцэрлэгийн барилгуудад хэмжилт, дулаан алдагдлын тооцоо хийж, тайлан дүгнэлт боловсруулсан.



Тайлант жил дараах төслүүдэд санал өгч, хамтарч ажилласан байна. Үүнд:

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийн нээлтийн семинар, “Барилгын эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах асуудалтай холбогдолтой норм стандартын хэрэгжилтийг хянаж шалгахад тулгардаг хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох”, “Барилгын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгох” хэлэлцүүлэг зэрэг уулзалт семинарт оролцож санал өгсөн.

“Агаарын бохирдлыг бууруулахад Монгол улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх” богино хугацааны төслийн хамрах хүрээнд гэр хороололд хэрэглэж буй бага оврын зуухыг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах талаар санал өгөв.

Барилгын эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хувийн хэвшлээс төсөл боловсруулан ажиллаж буй “Зохицол”-ийн танилцуулга, төслийн үр дүнгийн семинарт оролцон, төсөл хэрэгжүүлсэн барилгуудтай танилцаж санал солилцсон. Барилгуудын халаалтын шийдлийн талаар төслийн багтай шалны халаалт систем болон хэрэгцээний халуун усыг нарны хавтангаар халаах шийдлийн тухай санал солилцсон.

БНБД 23-02-09 Барилгын дулаан хамгаалалт, БД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт нормуудыг шинэчлэн боловсруулах, олон улсын жишигт нийцүүлэх талаар үндэслэл, тайлбар боловсруулан Барилгын салбарын норм, нормчлолын санд хүргүүлсэн.

Эрчим хүчний аудитын чиглэлийн Европын холбооны дараах стандартуудын орчуулгын төслүүдийг хянаж, санал өгөв.

- EN26247-1 Эрчим хүчний аудит. Ерөнхий шаардлага
- EN26247-2 Эрчим хүчний аудит. Барилга байгууламж
- EN26247-5 Эрчим хүчний аудит. Эрчим хүчний аудиторын эрх үүрэг

“Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд урамшуулал олгох журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцож журмыг батлуулсан.

“Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам” боловсруулах ажлын хэсэгт орж эрчим хүч хэмнэлтийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийг дэмжсэн тодорхой заалтууд тусгуулсан. Журам Засгийн газрын хуралдаанаар 2017 оны 9 дүгээр сард батлагдсан.

2017 үйл ажиллагааны товч дүгнэлт:

- “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор батлуулсан, Эрчим хүчний салбарын хэмжээнд 2018 оныг “Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн жил” болгох ажлыг санаачилж дэмжүүлж ажилласан нь эрчим хүчний хэмнэлтийн ажлыг салбарын хэмжээнд болон Улсын хэмжээнд өргөн хүрээтэй, далайцтай явуулах ажлын эхлэлийг тавьж өглөө.
- Эрчим хүчний хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг тогтмол зохион байгуулж ажилласнаар үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 74% нь өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах орон тооны ажилтныг томилон, эрчим хүч хэмнэлтийн менежерийн сургалтад хамруулсан байгаа нь бодлогын болон хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын ажиллах боловсон хүчний чадавхыг хангалттай бэлдэж байна гэсэн дүгнэлт хийх боломж олгож байна.
- “Эрчим хүчний аудит хийх гарын авлага”-ыг боловсруулж холбогдох гэрээний загвар, маягуудыг батлуусан мөн 27 үйлдвэрлэлийн, 17 барилгын эрчим хүчний аудитор батламж, гэрчилгээ олгож гадаад орны мэргэжлтнүүдээр давтан сургалт хийлгэсэн нь Аудитын үйл ажиллагааг жигдрүүлэх боловсон хүчний чадавхтай болох ажилд түлхэц өглөө.
- Эрчим хүчний аудитын жишиг төслийг үүрэг хүлээсэн 15 аж ахуйн нэгж, байгууллага дээр амжилттай хийлгэснээс “ДЦС-3” ТӨХК-нд “Монхорус интернейшнл” ХХК-тай хамтран эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн арга хэмжээг хэрэгжүүлэх жишиг (ЭСКО) төсөл хэрэгжүүлэх талаар бэлтгэл ажил ханган ажиллаж байгаа нь бусад станцуудад үлгэр жишээ авах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх суурь туршилт, хэрэгжүүлэлтийн ажил болно.
- Нийслэлийн Боловсролын газартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээл заах багш нарыг сургаж, заах хичээлийн 11 үзүүлэх материалыг бэлдэж сургуулийн 1-5 ангийн зорилтот бүлэгт хичээл зааж эхэлсэн нь “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.
- “Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ, хэмнэлтийн асуулт, хариулт” номыг гаргаж хэвлэлтэд оруулснаар хэмнэлтийн ажил хийх сонирхолтой иргэн ААНБ-дад чухал гарын авлага бэлдсэн.



2018 оны зорилт:

Эрчим хүчний зохицуулах хорооны ажлын төлөвлөгөөнд орсон дараах ажлуудын хэрэгжилтийг хангаж ажиллана.

I. “Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн жил” болгох тухай Эрчим хүчний яамны шийдвэрийг гаргуулах, тус яамтай хамтран нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

- Эрчим хүчний байгууллагуудын хэмнэлтийн менежерүүдийн 2017 оны ажлын тайланг авч дүгнэлт өгөх, 2018 оны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
- Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага (GGGI)-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр эрчим хүчний аудит хийсэн 15 аж ахуйн нэгж, байгууллагын аудитын зөвлөмжөөс 2018 он хэрэгжүүлж болох ажлуудыг хийлгэх, гүйцэтгэлийг хянах ажлыг хийнэ.

II. “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах ажлыг ЭХЯ-тай хамтран хийж Эрчим хүчний газрын ажлын чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлын хэрэгжилтийг хангана.

III. Эрчим хүчний хэмнэлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, мэргэжлийн үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2017 оны 12 сарын 04 өдрийн А/151 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, сайжруулах, харилцан уялдааг хангах ажлыг хийж гүйцэтгэнэ.

IV. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, бодит хэмнэлт гаргах үйл ажиллагааг урамшуулалт зохицуулалтын арга хэрэгслээр дэмжих;

- “Урамшуулалт зохицуулалт журам”-ын хэрэгжилтийг хангаж Үнэ тариф, зах зээлийн газартай хамтран ажиллана.

V. Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар хэрэглэгчдэд зориулсан үндэсний мэдээллийн цахим систем, мэдээллийн санг бий болгох, хэмнэлт, үр ашгийн талаар хэрэглэгчид, олон нийтэд сурталчлан таниулах;

- Батлагдсан хөтөлбөрийн дагуу 225 ерөнхий боловсролын сургуулийн 4075 бага ангийн багш нарыг бэлтгэж, 140,000 бага ангийн сурагчдад “Эрчим хүч-зохистой хэрэглээ” хичээл заах ажлыг зохион байгуулна.
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн мэдээллийн системийн ажлын батлагдсан даалгаврын дагуу мэдээллийн системийг хийлгэх, ажиллуулж эхлэх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг хийнэ;
- Бусад сурталчилгааны ажлуудыг төлөвлөгөөний дагуу явуулах

VI. Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах; эрчим хүчний 4 компанид хэмнэлтийн аудитын загвар төслийг хэрэгжүүлэх;

- ДЦС-4, Дарханы ДЦС ТӨХК, УБЦТС ТӨХК, ЦДҮС ТӨХК компаниудад хэмнэлтийн аудитын загвар төслийг хэрэгжүүлнэ.

VII. Эрчим хүчний зохицуулах хороог эрчим хүчний хэмнэлтийн загвар байгууллага болгох;

- Эрчим хүчний зохицуулах хорооны барилгын өргөтгөлийн ажлын явцад хяналт тавьж ажиллана.
- ИКОН ХХК-тай хамтарч хэрэгжүүлж байгаа дулааны үр ашгийн төслийг үргэлжүүлэн, үр ашгийг тооцож ажиллана.

VIII. Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх болон орон нутгийн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулзалт-зөвлөгөөнийг зохион байгуулах, техник, санхүү-эдийн засаг, хэмнэлтийн болон хүний нөөцийн бодлогын удирдамжаар хангах;

- Уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулахад идэвхтэй оролцож, эрчим хүчний хэмнэлтийн жишээ хэрэгжүүлэлт, гадаад орны туршлагаар танилцуулга бэлдэж илтгэл тавина.
- Орон нутгийн хэмнэлтийн менежерүүдэд давтан сургалт зохион байгуулах, хэмнэлтийн ажлыг зохион байгуулах арга зүйн туслалцаа өгөх ажлыг зохион байгуулна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ГАЗАР

Ц.АТАРЖАРГАЛ	Газрын дарга
Б.ЭНХЖАРГАЛ	Ахлах мэргэжилтэн
Ч.ӨНӨРЦЭЦЭГ	Ахлах мэргэжилтэн
П.ХИЙМОРЬСАЙН	Эрчим хүчний хэмнэлт хариуцсан мэргэжилтэн
Н.БАДАМЦЭЦЭГ	Эрчим хүчний хэмнэлт хариуцсан мэргэжилтэн
Б.ЦОЛМОН	Барилгын салбарын бодлогын уялдаа, барилгын эрчим хүчний хэмнэлт хариуцсан мэргэжилтэн
Д.НАРАНЦЭЦЭГ	Магадлан итгэмжлэл, мэдээлэл арга зүй хариуцсан мэргэжилтэн
Э.БОЛОРТУЯА	Эрчим хүчний аудитор, менежерийн сургалт хариуцсан мэргэжилтэн
Х.НОМИНБИЛЭГ	Статистик мэдээлэл, тайлан нэгтгэл хариуцсан мэргэжилтэн

